

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга 7	
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	24

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УСУГ	Ус сувгийн удирдах газар
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
САГ	Санхүүгийн аудитын газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ж.БАТСУУРЬ
ТАНАА

2020.03.13 № 06/826
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, 18.5 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-т заасны дагуу Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2019 оны жилийн санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус зохицуулах зөвлөлд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


Тус зохицуулах зөвлөл нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ 2014 оноос хойш шинэчлэн сайжруулаагүй, холбогдох стандарт, хууль тогтоомж, дүрэм журмын өөрчлөлтүүд хийгдээгүй, нийт 78.3 сая төгрөгийн орлого бууруулах бичилт хийсэн, 42.3 сая төгрөгийн урамшуулалт цалинг илүү олгосон, 24.4 сая төгрөгийн цалинг НДШ төлөлтийн тайланд дутуу тайлагнасан зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хуулийн шаардлагад нийцээгүй байна.

Үүрэг хариуцлага

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Ж.Батсуурь Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ шинэчлэх, өглөг, цалин хөлс, орлого, зардлуудыг үнэн зөв тооцож байх, холбогдох хууль журам зааврыг мөрдөж ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 17-оос 2020 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Голден пэйж Аудит ХХК-ийн аудитор Ц.Долгормаа, Я.Оюун аудиторын туслах Г.Ариун-Эрдэнэ нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2019 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/38 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь: “Монгол улсад ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг үр ашигтай явуулах нөхцөлийг бүрдүүлэн, Монгол хүний эрхийг хангасан баталгаатай, тэгш хүртээмжтэй, байгаль орчинд ээлтэй үйлчилгээг хөгжүүлэх, оновчтой зохицуулалтыг хийхэд оршино” гэж тодорхойлжээ.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны чиглэлийг усны үйлчилгээний төлбөр, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний тарифыг тогтоох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй байна гэж тодорхойлжээ.

Зохицуулах зөвлөлийн ажлын албадын 2019 онд хийхээр төлөвлөсөн үйл ажиллагааны гүйцэтгэлийг дурдвал:

- Тусгай зөвшөөрлийн алба 34 ажил хийхээр төлөвлөснөөс 33 ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд гүйцэтгэл нь 98.2 хувьтай байна.
- Үнэ тарифын алба 35 ажил хийхээр төлөвлөснөөс 34 ажлын хийж гүйцэтгэсэн бөгөөд гүйцэтгэл нь 98.9 хувьтай байна.
- Эрх зүй, мэдээлэл, захиргааны алба 32 ажил хийхээр төлөвлөснөөс 31 ажлын хийж гүйцэтгэсэн бөгөөд гүйцэтгэл нь 97.0 хувьтай байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын тухай хуулийн 1 дүгээр зүйл. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.15 дахь хэсэг нэмсүгэй, 9 зүгээр зүйлийн “9.15-д Зохицуулах зөвлөлд хот, суурины ус хангамж, ариутгах татуургын улсын байцаагч ажиллана. Улсын байцаагчийн эрхийг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.4-т заасны дагуу олгоно.”, 2 дугаар зүйл. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын байгууллага” гэсний дараа “болон эрх бүхий улсын байцаагч” гэж нэмсүгэй.
- Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлд “нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ”
- Хөдөлмөрийн тухай хуулийн 76 дугаар зүйлд “нийтээр амрах баярын өдөр”
- ХХОАТ-ын тухай хуулийн 24 дүгээр зүйлд “албан татварын хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлэх” гэсэн заалтуудад тус тус өөрчлөлт орсон байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус зохицуулах зөвлөлийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Acolus программ хангамж ашиглаж байна.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, тодруулга нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 8 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,188.0 сая төгрөгөөс тооцон 11.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өөрчлөөгүй.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 79.7 сая төгрөгөөр буюу 21.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/сая төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	172.2	162.4	-9.8
Авлага	95.5	62.0	-33.6
Бараа материал	9.1	14.3	5.2
Үндсэн хөрөнгө	191.4	305.0	113.6
Үндсэн хөрөнгийн элэгдэл	-108.3	-101.2	7.1
Биет бус хөрөнгө	31.8	31.8	0.0
Биет бус хөрөнгийн элэгдэл	-15.4	-18.3	-2.9
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>376.3</u>	<u>456.0</u>	<u>79.7</u>
Байгууллагад төлөх өглөг	0.4	8.3	7.9
Татварын өглөг /ТӨҮГ/	0.1	0.0	-0.1
Өмч: - төрийн	0.0	0.0	0.0
Өмнөх үеийн үр дүн	375.8	375.8	0.0
Тайлант үеийн үр дүн	0.0	71.9	71.9
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>376.3</u>	<u>456.0</u>	<u>79.7</u>

Өмнөх оны үзүүлэлтээс авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Авлага дансны үлдэгдэл 33.6 сая төгрөгөөр буурсан нь зохицуулах үйлчилгээний тооцооны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс буурсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 113.6 сая төгрөгөөр өссөн нь 120.0 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл худалдаж авсантай холбоотой. ТӨБЗГ-ын 2019 оны 298 тоот тогтоолын дагуу акталж устгасан 37.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хассан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 7.9 сая төгрөгөөр өссөн нь 3 байгууллагын өглөг байна.

2.9. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 385 дугаар тогтоолоор тус зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 927.6 сая төгрөгийг өөрийн орлогоос, 120.0 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр, зардлын төлөвлөгөөг 897.7 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлын нийт гүйцэтгэл 866.0 сая төгрөг буюу 96.5 хувьтай байна.

Өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 927.6 сая төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 914.5 сая төгрөг буюу 13.1 сая төгрөгөөр тасарсан байна.

Туслах үйл ажиллагааны орлого, хүүгийн орлогын төлөвлөгөөгүй боловч гүйцэтгэлээр нийт 0.6 сая төгрөгийн туслах үйл ажиллагааны орлого, 0.2 сая төгрөгийн хүүгийн орлого олсон байна.

Нэмэлт төсөв: Төв болон суурин газрын ундны усны чанарын судалгаа, мэдээллийн сан байгуулах технологийн шийдэл сонгох төслийн санхүүжилт 322.7 сая төгрөг хүлээн авч, зарцуулсан.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 8 эрсдэл тодорхойлж нийт 10 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 161.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 0.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 161.3 сая төгрөгийн алдаа зөрчилд давтан гаргахгүй байх 9 зөвлөмж өгч Менежментийн захидалд тусгалаа.

Аудитаар дараах 0.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Профессорын нэмэгдлийг 1 сард 15.0 хувиар буюу 0.4 сая төгрөгөөр илүү тооцож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус зохицуулах зөвлөлийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, цалин урамшуулал, орлого зэргийг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 114 мэдээллийг хугацаанд нь, 20 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 168.0 сая төгрөгийн 3 албан шаардлага өгснөөс хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийт 6 зөвлөмж өгснөөс 4 зөвлөмж хэрэгжиж, 2 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна. Зөвлөмжийн хэрэгжилт 75.0 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт:

Тус зохицуулах зөвлөл нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ 2014 оноос хойш шинэчлэн сайжруулаагүй, холбогдох стандарт, хууль тогтоомж, дүрэм журмын өөрчлөлтүүд хийгдээгүй, бодлого горимууд нь шаардлага хангахгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалтыг зөрчсөн.

3.1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан тоо мэдээ буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль тогтоомж хэрэгжихгүй байх;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ өөрийн байгууллагын онцлогт тохируулан шинэчлэн боловсруулж, баталж мөрдөн ажиллах;

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

БХБЯ болон Сангийн яамны зөвлөмжийн дагуу нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2019 онд батлан гаргасан. Зөвлөлийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх ажлыг 2020 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

3.2 Орлого данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Зохицуулах үйлчилгээний хөлсний орлогыг төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй. Тусгай зөвшөөрөл эзэмшигч 198 байгууллагаас 34 байгууллага тусгай зөвшөөрлийн төлбөр төлөөгүй, үүнээс тайлант онд шинээр тусгай зөвшөөрөл эзэмшигч болсон, сунгалт хийлгэсэн 3 байгууллагын 0.5 сая төгрөгийг тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” 14.4.5-д “Бүх орлого” гэсэн заалтыг зөрчсөн.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан тоо мэдээ буруу илэрхийлэгдэх, холбогдох журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх;

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Зохицуулах үйлчилгээний орлогыг төлбөрийн баримтаар баталгаажуулан, үнэн зөв бүртгэж тайлагнадаг байх;

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид анхаарч ажиллана.

3.3 Орлого данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Орлого дансыг 78.3 сая төгрөгөөр бууруулах бичилт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” 14.4.5-д “Бүх орлого”, 14.4.6-д “бүх зардал” гэсэн заалтуудыг зөрчсөн.

Эрсдэл:

Холбогдох хууль тогтоомж, тушаал шийдвэр хэрэгжихгүй байх;

3.3.2 Өгсөн зөвлөмж:

Орлогыг үнэн зөв бүртгэж, тайлагнадаг байх;

3.3.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

БХБЯ-ны захиалгаар НҮБ, Хүүхдийн сангийн санхүүжилтээр Тогтвортой хөгжлийн зорилт 6.1-6.3 хэрэгжүүлэх Үндэсний Зөвлөлдөх уулзалтыг 2019.10.23-24 нд зохион байгуулсан. Уг арга хэмжээг зохион байгуулах төсөвлөгдсөн зардлыг БХБЯ болон Хүүхдийн сангийн зөвшөөрлөөр шилжүүлж, тайлагнасан.

Мөн зохицуулах Зөвлөл нь Олон улсын усны холбооны гишүүн бөгөөд тус холбооны шугамаар харилцагч тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын мэргэжлийн төлөөллүүдийг гишүүнчлэлийн хөнгөлөлттэй нөхцөлөөр туршлага судлуулах зорилгоор явуулдаг. Байгууллагууд нь зөвлөлөөр дамжуулж, оролцооны зардлыг шилжүүлдэг. 56.7 сая төгрөг нь УСУГ-аас ирсэн шилжүүлэг болно.

3.4 Цалин хөлсний данстай холбоотой

3.4.1 Илрүүлэлт:

Зөвлөлийн даргын 2019.11.15-ны А/46 тоот тушаалаар ажилчдад 1.5 сарын цалинтай тэнцэх хэмжээний 42.3 сая төгрөгийн урамшуулал бодож олгосон нь Засгийн газрын 2018.12.19-ний 385 дугаар тогтоолыг зөрчсөн.

3.4.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан тоо мэдээ буруу илэрхийлэгдэх;

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Цалингийн урамшууллыг Засгийн газрын тогтоолтой уялдуулан олгох;

3.4.4 Байгууллагаас ирүүлсэн хариу:

Зохицуулах зөвлөл нь 2019 оны батлагдсан төсвийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3.2, Хөдөлмөрийн дотоод журмын 5.11, 11.3 болон Даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн цалинг олгосон.

3.5 Өглөг данстай холбоотой

3.5.1 Илрүүлэлт:

Өглөгийн үлдэгдэл 8.3 сая төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчсөн.

3.5.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан тоо мэдээ буруу илэрхийлэгдэх, ашиглан үүсэх;

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Өглөгийг үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулдаг байх;

3.5.4 Байгууллагаас ирүүлсэн хариу:

Цаашид анхаарч ажиллана.

3.6 Бусад зардал данстай холбоотой

3.6.1 Илрүүлэлт:

Эмон ХХК-тай байгуулсан Гарааш түрээслэх, түрээслүүлэх гэрээг шинэчлээгүй, гараашийн төлбөрийг аккруэл сууриар бүртгээгүйгээс 0.7 сая төгрөгийн зардлыг дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.6.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан тоо мэдээ буруу илэрхийлэгдэх, ашиглан үүсэх;

3.6.3 Өгсөн зөвлөмж:

Түрээсийн зардлыг үнэн зөв бүртгэж, тайлагнаж байх.

3.6.4 Байгууллагаас ирүүлсэн хариу:

Цаашид анхаарч ажиллана. Тайлант онд худалдан авсан 1 машины тоог нэмж, гэрээгээ шинэчлэнэ.

3.7 Олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж данстай холбоотой

3.7.1 Илрүүлэлт:

Үйл ажиллагааны төсөвт тусгагдсан 2 байгууллагын гишүүнчлэлийн хураамжийн зардал 3.8 сая төгрөгийг бүртгэж, тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.7.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан тоо мэдээ буруу илэрхийлэгдэх, ашиглан үүсэх;

3.7.3 Өгсөн зөвлөмж:

Гишүүнчлэлийн хураамжийн зардлыг үнэн зөв бүртгэж, тайлагнах.

3.7.4 Байгууллагаас ирүүлсэн хариу:

Зохицуулах зөвлөл нь Дэлхийн Усны Чанарын Холбоо, Олон Улсын усны холбооны гишүүн, Азийн усны хорооны удирдах зөвлөлийн гишүүн болно. Олон улсын усны байгууллагууд нь тус зохицуулах зөвлөлийг хөгжиж байгаа орны гишүүн байгууллага, ази дахь анхны хараат бус усны зохицуулах агентлаг хувиар болон тухайн жилийн оролцоо, идэвх санаачилга зэргийг харгалзан үзэж жил бүр харилцан адилгүй хураамж нэхэмжилдэг, Иймд гишүүнчлэлийн хураамжийг урьдчилан тооцох боломжгүй юм.

3.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс данстай холбоотой

3.8.1 Илрүүлэлт:

Төслийн цалингаас 24.4 сая төгрөгийн цалинг НДШ-ийн тайланд тусгаагүй 3.0 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал үр дүнгийн тайланд дутуу илэрхийлэгдсэн байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ.” заалтыг зөрчсөн.

3.8.2 Эрсдэл:

Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж хэрэгжихгүй байх;

3.8.3 Өгсөн зөвлөмж:

Цалин хөлсийг Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд тухай бүр бүрэн тайлагнадаг байх;

3.8.4 Байгууллагаас ирүүлсэн хариу:

Засгийн газрын 2019 оны Нийтийн Аж ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай 474 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангуулах, Нийслэл болон зарим аймгийн ЗДТГ-ын захиалгаар Шинжлэх ухааны академитай хамтран Төв, суурин газрын ундны усны чанарын судалгаа, мэдээллийн сан байгуулах, технологийн шийдэл сонгох төслийн багт ажилласан ажилтнуудын цалингийн НДШ-ийг 2020 оны 1 сард тайлагнасан болно.

3.9 Мөнгөн хөрөнгө данстай холбоотой

3.9.1 Илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгийн тайланд хүчингүй болсон анхан шатны баримттай, дэмжих баримтад гарын үсэг, тамга тэмдэг дутуу, төлбөрийн баримт дутуу байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалыг зөрчсөн.

3.9.2 Эрсдэл:

Холбогдох хууль тогтоомж, тушаал шийдвэр хэрэгжихгүй байх;

3.9.3 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны хүчин төгөлдөр баримтаар ажил гүйлгээг бүртгэж, төлбөрийн баримтыг тухай бүр бүрдүүлэн ажиллах;

3.9.4 Байгууллагаас ирүүлсэн хариу:

Харилцагч байгууллагуудаас худалдан авсан болон ажил үйлчилгээ хүлээн авсан төлбөрийн баримтын НӨАТ-ын бичилтийг цаашид анхаарч ажиллах болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>276,805,120.54</u>	<u>238,675,371.79</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	172,175,935.99	162,382,485.68
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	71,028.63	142,813.56
31140	Касс арилжааны банк	71,028.63	142,813.56
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	172,104,907.36	162,239,672.12
3121	Төгрөг	172,104,907.36	162,239,672.12
31213	Арилжааны банк дахь харилцах	172,104,907.36	77,455,895.52
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах		84,783,776.60
33	АВЛАГА	95,547,010.92	61,962,487.48
335	Бусад авлага	95,547,010.92	61,962,487.48
3351	Байгууллагаас авах авлага	95,547,010.92	61,962,487.48
35	БАРАА МАТЕРИАЛ	9,082,173.63	14,330,398.63
351	Түүхий эд материал	412,893.00	1,046,493.00
35110	Тусгай зориулалттай материал	412,893.00	1,046,493.00
354	Хангамжийн материал	8,669,280.63	13,283,905.63
35410	Бичиг хэргийн материал	2,737,244.40	7,741,924.40
35420	Аж ахуйн материал	3,791,133.00	3,751,353.00
35440	Түлш, шатах тослох материал	1,890,903.23	1,573,839.23
35460	Хүнсний материал		216,789.00
35470	Бусад хангамжийн материал	250,000.00	
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>99,504,215.21</u>	<u>217,372,350.59</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	99,504,215.21	217,372,350.59
392	Биет хөрөнгө	83,054,375.13	203,789,150.49
39203	Авто-тээврийн хэрэгсэл	75,400,000.00	195,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	34,992,499.82	52,532,499.80
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	62,893,049.00	57,496,090.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	48,559,698.80	20,432,764.72
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,017,450.00	50,028,940.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	24,613,665.25	28,080,354.99
39214	Бусад үндсэн хөрөнгө	869,990.00	869,990.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	163,000.00	163,000.00
39217	Ном	1,202,750.00	1,202,750.00
393	Биет бус хөрөнгө	16,449,840.08	13,583,200.10
39301	Програм хангамж	31,834,920.00	31,834,920.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	15,385,079.92	18,251,719.90
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>376,309,335.75</u>	<u>456,047,722.38</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>507,646.65</u>	<u>8,358,000.01</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	507,646.65	8,358,000.01
413	Өглөг	507,646.65	8,358,000.01
4136	Бусад өглөг	507,646.65	8,358,000.01
41361	Байгууллагад төлөх өглөг	400,000.00	8,340,000.00

41363	Татварын өглөг /ТӨҮГ/	107,646.65	18,000.01
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>375,801,689.10</u>	<u>447,689,722.37</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>375,801,689.10</u>	<u>447,689,722.37</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	20,000.00	20,000.00
51101	Өмч: - төрийн	20,000.00	20,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	<u>375,781,689.10</u>	<u>447,669,722.37</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	375,781,689.10	375,781,689.10
51220	Тайлант үеийн үр дүн		71,888,033.27
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>376,309,335.75</u>	<u>456,047,722.38</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	695,241,973.68	1,259,895,208.11
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	695,241,973.68	937,195,108.11
120	Нийтлэг татварын бус орлого	695,241,973.68	937,195,108.11
120002	Хүүгийн орлого	5,208,232.91	6,422,402.11
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	689,718,047.54	930,772,706.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	689,451,047.54	927,623,990.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	267,000.00	632,750.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	1,802,196.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	713,770.00
120009	Бусад орлого	315,693.23	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	322,700,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	322,700,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	322,700,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	670,158,638.72	1,188,007,174.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	604,060,620.72	1,188,007,174.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	588,774,220.72	1,158,381,044.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	348,432,815.67	526,557,251.00
210101	Үндсэн цалин	322,927,265.67	495,357,251.00
210105	Гэрээт ажлын хөлс	25,505,550.00	31,200,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,512,706.19	66,782,391.31
210201	Тэтгэврийн даатгал	27,298,976.62	45,798,021.31
210202	Тэтгэмжийн даатгал	3,395,131.66	5,257,501.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,716,105.74	4,206,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	645,680.29	1,005,865.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,456,811.88	10,515,004.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,642,000.00	58,704,000.00
210304	Байрны түрээс	52,642,000.00	58,704,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,315,659.14	32,892,142.90
210401	Бичиг хэрэг	5,410,906.00	18,349,960.00
210402	Тээвэр, шатахуун	6,248,063.78	4,662,739.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,232,608.36	6,912,451.90
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,424,081.00	2,966,992.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,616,200.00	6,668,775.00
210604	Урсгал засвар	6,616,200.00	6,668,775.00
2107	Томилолт, зочны зардал	44,280,000.73	72,117,121.00
210701	Гадаад албан томилолт	37,483,874.50	58,745,746.00
210702	Дотоод албан томилолт	6,796,126.23	12,903,385.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	467,990.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,114,967.80	242,297,199.01

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,699,000.00	230,981,527.01
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,479,270.00	2,647,622.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	171,811.00	96,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	54,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	6,054,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	273,686.80	203,700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	437,200.00	312,950.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,859,871.19	152,362,164.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,000.00	70,435,730.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	45,223,463.25	49,097,370.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,582,407.94	32,829,064.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,286,400.00	29,626,130.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,495,671.00	971,480.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	3,495,671.00	971,480.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,790,729.00	28,654,650.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,790,729.00	28,654,650.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	66,098,018.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	66,098,018.00	-
221001	Их засвар	66,098,018.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>25,083,334.96</u>	<u>71,888,033.27</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>25,083,334.96</u>	<u>71,888,033.27</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	676,805,909.93	1,244,199,621.13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	676,805,909.93	921,499,521.13
120	Нийтлэг татварын бус орлого	676,805,909.93	921,499,521.13
120002	Хүүгийн орлого	5,208,232.91	402,257.69
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	671,597,677.02	915,157,263.44
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	670,930,677.02	914,524,513.44
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	667,000.00	632,750.00
120009	Бусад орлого		5,940,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	322,700,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	322,700,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		322,700,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	634,649,076.12	1,103,719,871.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	634,649,076.12	1,103,719,871.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	618,681,475.12	1,083,921,685.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	349,321,130.68	527,133,754.71
210101	Үндсэн цалин	260,335,718.68	390,487,645.71
210102	Нэмэгдэл	36,133,662.00	16,231,053.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,571,200.00	34,188,000.00
210104	Урамшуулал		55,027,056.00
210105	Гэрээт ажлын хөлс	26,280,550.00	31,200,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,566,744.53	65,848,649.25
210201	Тэтгэврийн даатгал	29,723,903.28	65,848,649.25
210202	Тэтгэмжийн даатгал	2,802,409.19	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,241,927.94	-
210204	Ажилгүйдлийн даатгал	527,136.20	-
210205	Эрүүл мэндийн даатгал	5,271,367.92	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,642,000.00	54,060,000.00
210304	Байрны түрээс	52,642,000.00	54,060,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,570,659.36	27,484,766.90
210401	Бичиг хэрэг	5,731,114.00	8,357,700.00
210402	Тээвэр, шатахуун	7,662,500.00	9,621,690.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,370,608.36	7,006,451.90
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,806,437.00	2,498,925.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,829,605.00	5,535,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,659,305.00	-
210604	Урсгал засвар	8,170,300.00	5,535,500.00
2107	Томилолт, зочны зардал	44,798,278.50	66,716,946.00
210701	Гадаад албан томилолт	37,807,852.50	59,468,146.00

210702	Дотоод албан томилолт	6,990,426.00	7,248,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,525,267.80	258,553,753.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	238,170,996.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,479,270.00	2,883,646.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	151,811.00	220,711.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	42,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		16,757,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	447,686.80	478,900.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	402,500.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	94,427,789.25	78,588,316.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,710,353.00	59,895,207.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	86,717,436.25	18,693,109.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,967,601.00	19,798,185.58
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,495,671.00	971,480.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	3,495,671.00	971,480.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,471,930.00	18,826,705.58
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,471,930.00	18,826,705.58
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>42,156,833.81</u>	<u>140,479,749.69</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	89,138,538.00	150,273,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	89,138,538.00	150,273,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	89,138,538.00	150,273,200.00
221001	Их засвар	66,238,538.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,900,000.00	150,273,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(89,138,538.00)</u>	<u>(150,273,200.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(46,981,704.19)	(9,793,450.31)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	219,157,640.18	172,175,935.99
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	172,175,935.99	162,382,485.68

4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,000.00	350,698,354.14	350,718,354.14
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,000.00	350,698,354.14	350,718,354.14
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	25,083,334.96	25,083,334.96
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,000.00	375,781,689.10	375,801,689.10
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,000.00	375,781,689.10	375,801,689.10
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	71,888,033.27	71,888,033.27
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,000.00	447,669,722.37	447,689,722.37

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		172,175,938.99	172,175,938.99	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,047,625,900.00	1,015,822,075.44	31,803,824.56	97.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	897,725,900.00	865,968,775.44	31,757,124.56	96.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	874,192,900.00	846,170,589.86	28,022,310.14	96.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	550,831,500.00	527,133,754.71	23,697,745.29	95.7
210101	Үндсэн цалин	397,440,000.00	390,487,645.71	6,952,354.29	98.3
210102	Нэмэгдэл	22,735,500.00	16,231,053.00	6,504,447.00	71.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	46,464,000.00	34,188,000.00	12,276,000.00	73.6
210104	Урамшуулал	52,992,000.00	55,027,056.00	(2,035,056.00)	103.8
210105	Гэрээт ажлын хөлс	31,200,000.00	31,200,000.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,099,800.00	65,848,649.25	251,150.75	99.6
210201	Тэтгэврийн даатгал	66,099,800.00	65,848,649.25	251,150.75	99.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,060,000.00	54,060,000.00	-	100.0
210304	Байрны түрээс	54,060,000.00	54,060,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	28,331,200.00	27,904,666.90	426,533.10	98.5
210401	Бичиг хэрэг	8,912,000.00	8,777,600.00	134,400.00	98.5
210402	Тээвэр, шатахуун	9,624,300.00	9,621,690.00	2,610.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,282,400.00	7,006,451.90	275,948.10	96.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,512,500.00	2,498,925.00	13,575.00	99.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,536,000.00	5,535,500.00	500.00	100.0
210604	Урсгал засвар	5,536,000.00	5,535,500.00	500.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	65,794,400.00	66,716,946.00	(922,546.00)	101.4
210701	Гадаад албан томилолт	58,400,400.00	59,468,146.00	(1,067,746.00)	101.8
210702	Дотоод албан томилолт	7,394,000.00	7,248,800.00	145,200.00	98.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,910,000.00	20,382,757.00	4,527,243.00	81.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00		2,500,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	4,500,000.00	2,883,646.00	1,616,354.00	64.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	360,000.00	220,711.00	139,289.00	61.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	42,000.00	24,000.00	63.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,004,000.00	16,757,500.00	246,500.00	98.6
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	480,000.00	478,900.00	1,100.00	99.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78,630,000.00	78,588,316.00	41,684.00	99.9

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн
2019 оны санхүүгийн тайлангийн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	59,910,000.00	59,895,207.00	14,793.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,720,000.00	18,693,109.00	26,891.00	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,533,000.00	19,798,185.58	3,734,814.42	84.1
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,773,000.00	971,480.00	3,801,520.00	20.4
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	4,773,000.00	971,480.00	3,801,520.00	20.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,760,000.00	18,826,705.58	(66,705.58)	100.4
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	18,760,000.00	18,826,705.58	(66,705.58)	100.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	149,900,000.00	149,853,300.00	46,700.00	100.0
2200	Дотоод эх үүсвэрээр	149,900,000.00	149,853,300.00	46,700.00	100.0
222001	Тоног төхөөрөмж	149,900,000.00	149,853,300.00	46,700.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,047,625,900.00	915,304,848.53	132,321,051.47	87.4
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,047,625,900.00	915,304,848.53	132,321,051.47	87.4
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	927,625,900.00	914,524,513.44	13,101,386.56	98.6
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		622,750.00	(622,750.00)	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	120,000,000.00		120,000,000.00	-
1200044	Хүүгийн орлогоос санхүүжих		157,585.09	(157,585.09)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		172,175,935.99	(172,175,935.99)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		77,598,709.00	(77,598,709.00)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага				
610002	Төсвөөс гадуур байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	23	22	1	95.7
620001	Удирдах ажилтан	4	4	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	18	20	(2)	111.1
620003	Үйлчлэх ажилтан	-	-	-	-
620004	Гэрээт ажилтан	-	-	-	-

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		904,284,131.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ		904,284,131.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		895,682,231.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		57,095,173.00
210101	Үндсэн цалин		57,095,173.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		6,867,837.00
210201	Тэтгэврийн даатгал		6,867,837.00
2104	Хангамж, бараа материалын зардал		37,510,405.00
210402	Тээвэр, шатахуун		590,000.00
210404	Ном, хэвлэл		8,305,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		230,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		28,385,405.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		213,391,346.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		177,315,500.00
210602	Тавилга		7,905,200.00
210604	Урсгал засвар		28,170,646.00
2107	Томилолт, зочны зардал		25,455,400.00
210701	Гадаад албан томилолт		5,300,000.00
210702	Дотоод албан томилолт		20,155,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		527,500,811.13
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		527,500,811.13
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		27,861,259.18
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		27,861,259.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		8,601,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		8,601,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		8,601,900.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		904,284,131.31
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		904,284,131.31
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		70,123,974.69
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		420,198,456.62
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		413,961,700.00

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.03.11	Аудитын нэр: 2019 оны Санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код: САГ-2020/84/СТА-
Шалгагдсан байгууллагын нэр: Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл	Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тус зохицуулах зөвлөл нь НБББББ-ээ 2014 оноос хойш шинэчлэн сайжруулаагүй, холбогдох стандарт, хууль тогтоомж, дүрэм журмын өөрчлөлтүүд хийгдээгүй, бодлого горимууд нь шаардлага хангахгүй байна		Аудитын зөвлөмж	Дарга, Нягтлан бодогч	Ж.Батсуурь, Д.Сэлэнгэ
2	Зохицуулах үйлчилгээний хөлсний орлогыг төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй. Тусгай зөвшөөрөл эзэмшигч 198 байгууллагаас 34 байгууллага тусгай зөвшөөрлийн төлбөр төлөөгүй, үүнээс тайлант онд шинээр тусгай зөвшөөрөл эзэмшигч болсон, сунгалт хийлгэсэн 3 байгууллагын 0.5 сая төгрөгийг тайлагнаагүй байна.	0.5	Аудитын зөвлөмж	Дарга, Нягтлан бодогч	Ж.Батсуурь, Д.Сэлэнгэ
3	Бусад орлого дансыг 56.7 сая төгрөгөөр бууруулах бичилт хийсэн	56.7	Аудитын зөвлөмж	Дарга, Нягтлан бодогч	Ж.Батсуурь, Д.Сэлэнгэ
4	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих орлогыг 21.6 сая төгрөгөөр бууруулах бичилт хийж уг дүнгээр орлого, зардал дутуу илэрхийлэгдсэн. Бууруулсан зардлууд төлбөрийн баримтаар баталгаажуагүй.	21.6	Аудитын зөвлөмж	Дарга, Нягтлан бодогч	Ж.Батсуурь, Д.Сэлэнгэ

5	Зөвлөлийн даргын 2019.11.15-ны А/46 тоот тушаалаар 1.5 сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуулалд 42,4 сая төгрөг бодож олгосон. Профессорын нэмэгдлийг 1 сард 15 хувиар буюу 0.4 сая төгрөгөөр илүү тооцож олгосон.	42.8	Аудитын зөвлөмж	Дарга, Нягтлан бодогч	Ж.Батсуурь, Д.Сэлэнгэ
6	Эмон ХХК-тай байгуулсан Гарааш түрээслэх, түрээслүүлэх гэрээг шинэчлээгүй, гараашийн төлбөрийг аккруэл сууриар бүртгээгүйгээс 0,6 сая төгрөгийн зардлыг өмнөх онд илүү, тайлант онд дутуу тайлагнасан байна.	0.6	Аудитын зөвлөмж	Дарга, Нягтлан бодогч	Ж.Батсуурь, Д.Сэлэнгэ
7	Үйл ажиллагааны төсөвт тусгагдсан 2 байгууллагын гишүүнчлэлийн хураамжийн зардал 3.8 сая төгрөгийг бүртгэж, тайлагнаагүй.	3.8	Аудитын зөвлөмж	Дарга, Нягтлан бодогч	Ж.Батсуурь, Д.Сэлэнгэ
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлсөөр тайлагнасан төслийн ажилчдын цалингаас 24.4 сая төгрөгийг НДШ төлөлтийн тайланд дутуу тайлагнасан. Дутуу тайлагнасан төслийн цалинтай холбоотой НДШ-ийн зардал 3.0 сая төгрөг байна.	24.4	Аудитын зөвлөмж	Дарга, Нягтлан бодогч	Ж.Батсуурь, Д.Сэлэнгэ
9	Мөнгөн хөрөнгийн тайланд хүчингүй болсон анхан шатны баримттай, дэмжих баримтад гарын үсэг, тамга тэмдэг дутуу, төлбөрийн баримт дутуу байна.		Аудитын зөвлөмж	Дарга, Нягтлан бодогч	Ж.Батсуурь, Д.Сэлэнгэ
10	Өглөгийн үлдэгдэл 8.3 сая төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	8.3	Аудитын зөвлөмж	Дарга, Нягтлан бодогч	Ж.Батсуурь, Д.Сэлэнгэ
	Дүн	161.7			

